

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 7.1-д “Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ” гэж заасны 7.1.4-д “Мэргэшсэн чадварлаг байнгын бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөн, гал, цохилтын өндөр боломжтой хуурай замын цэргийн нэгтгэл, анги, салбарын тоог нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний ачаа, тээврийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай техник, хэрэгслээр хангана” гэснийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулаад байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг удирдлага болгон Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан ба улсын төсвөөс гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцсон болно.

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгана.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох шаардлагагүй гэж үзсэн болно.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Мөн хэлэлцээрийн дагуу манай улсад Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах үйл ажиллагааг нь буцалтгүй тусламжийн хүрээнд хийгдэх тул улсын төсвөөс ямар нэгэн нэмэлт зардал шаардахгүй болно.